

Төлөвлөгөөт хяналт шалгалт
хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Санхүүгийн хяналт аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт аудитын албаны даргын баталсан 2017 оны 05 сарын 22-ны 1/10 дугаар удирдамжийн дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтийг хангуулах, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, албан тушаал, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч О.Гантуяа
2017 оны 05 дугаар сарын 23-аас ажлын 7 хоног

Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр

Хутаг-өндөр сумын Сум дундын эмнэлгийн 2015, 2016 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтанд хамрагдсан асуудал

Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал

Үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн байдал

Харилцах дансны болон кассын орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримтууд, бараа материалын тайлан, хөрөнгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, хөрөнгийн тооллого, тооцоо бодолтын байдал

Байгууллага хоорондын тооцоо өглөг авлага, түүний баталгаажуулалт, бүртгэл тайланд тусгасан байдал

Ажиллагсдын цалин хөлс, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу тогтоож, бодож олгосон байдал

Гадаад, дотоод албан томилолтын зардлын тооцоо төлсөн байдал

Автомашин ашиглалт, шатахуун, сэлбэгийн тооцоо бодолтын байдал

Зээл тусламж, эргэж төлөгдөх нөхцлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр дүн

Тэмдэглэлт өдөр, ой, баяр наадамд зарцуулсан хөрөнгийн байдал

Нягтлан бодогчийн хууль тогтоомжинд заасан үүргийн биелэлт

Өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, актын барагдуулалт Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал

Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Хутаг-өндөр сумын Сум дундын эмнэлэг нь дарга, их эмч 6, статистикч бага эмч 1, эх баригч бага эмч 2, багийн бага эмч 4, ахлах сувилагч 1, уламжлалын бага эмч 1, сургалтын арга зүйч 1, лаборант, вакцинактор хүүхдийн сувилагч 1, рентген техникч нярав 1, мэс заслын сувилагч 1, нягтлан бодонч 1, ээлжийн сувилагч 6, үйлчлэгч 7, тогооч, жолооч, жолооч слесарь, галч тус бүр 1 нийт 39 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2015 оны 01 сарын 01-нээс 2015 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 1-р гарын үсгийг дарга Н.Эрдэнэчимэг, 2016 оны 01 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 1-р гарын үсгийг дарга Б.Туяацэцэг, 2015 оны 01 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 2-р гарын үсгийг нягтлан бодогч Н.Пэлжир нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 041320001 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 041320401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

Өмнөх шалгалтын талаар

Булган аймгийн Аудитын газраас Хутаг-өндөр сумын Сум дундын эмнэлгийн 2015 оны 12 сарын 31-ний өдрөөрх, 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж дүгнэжээ.

Сум дундын эмнэлгийн 2015, 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал

Сум дундын эмнэлгийн 2015, 2016 оны касс, харилцахын баримт, няравын материалын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, эрхлэгчийн тушаал, цалингийн карт, цалин олгох хүснэгт, нийгмийн даатгалын, татварын, санхүүгийн тайлан, 2015, 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын газрын дүгнэлт зэрэг баримт материалуудад тулгуурлан дарга Б.Туяацэцэг, нягтлан бодогч Н.Пэлжир, Мөнх-эрдэнэ нярав Х.Мөнхцэцэг нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Санхүүжилт, орлогын талаар: /мянган төгрөг/

2015 онд төсвөөс 480797.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 483007.3 мянган төгрөгийг авч, үндсэн үйл ажиллагааны орлогыг 1375.0 мянган төгрөгөөр төлөвлөж, 832.8 мянган төгрөгийг оруулж, ЭМД-ын сангаас 27500.0 мянган төгрөгийн санхүүжилтээр авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 27417.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас тэтгэмжийн 13469.4 мянган төгрөг, өмнөх оны төвлөрүүлэлтийн авлага 833.3 мянган төгрөг, ойн ангиас ногоон байгууламж байгуулахад 797.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн 550.2 мянган төгрөг нийт 526908.7 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

2016 онд төсвөөс 480111.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 479694.6 мянган төгрөг, ЭМД-ын сангаас 50675.0 мянган төгрөгийн санхүүжилтээр авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 50675.0 мянган төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж 1757.8 мянган төгрөгийг авч, нэмэлт санхүүжилтийн дансаар 315.2 мянган төгрөг нийт 532442.6 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлын талаар /мян.төг/

2015 онд төсөвт зардлыг 509672.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 515783.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажилчдын цалинд 350749.8 мянган төгрөг, гэрээт ажилчдын цалинд 3500.0 мянган төгрөг, урамшуулалт цалинд 22216.7 мянган төгрөг, ндш-д 40708.8 мянган төгрөг, тогтмол зардалд 26198.6 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 15734.9 мянган төгрөг, нормативт зардал буюу эм, хоол хүнс 35991.3 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 1582.4 мянган төгрөг, урсгал засвар 539.9 мянган төгрөг, томилолт 490.0 мянган төгрөг, төлбөр хураамж бусад татварууд 414.8 мянган төгрөг, жижиг эд хогшил 349.7 мянган төгрөг, хог хаягдал 679.7 мянган төгрөг, хөтөлбөр төсөл 1168.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 550.0 мянган төгрөг тус тус зарцуулж, 2 хүнд ХЧТА-ны тэтгэмж 3665.9 мянган төгрөг, 1 хүний ЖА-ны тэтгэмж нийт 8533.7 мянган төгрөгийг өгч, үлдэгдэл 11126.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2015 оны 04 сарын 28-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар 36 ажилтанд 25-40%-иар 5512.4 мянган төгрөг, 2015 оны 07 сарын 27-ны өдрийн Б/32 дугаар тушаалаар 19 ажилтанд 15-40%-иар 2319.6 мянган төгрөг, 2015 оны 10 сарын 28-ны өдрийн Б/59 дугаар тушаалаар 27 ажилтанд 15-45%-иар 4659.1 мянган төгрөг, 2015 оны 12 сарын 21-ний өдрийн 64 дугаар тушаалаар 33 ажилтанд 20-100%-иар 13430.6 мянган төгрөг нийт 25921.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

2015 оны 01 сарын 19-ний өдрийн Б/02 дугаар захирамжаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тул 1 сарын үндсэн цалингаар хүүхдийн их эмч Р.Оюунчимэгт 634.9 мянган төгрөг, 2015 оны 12 сарын 21-ний өдрийн Б/64 дугаар захирамжаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тул 1 сарын үндсэн цалингаар хүүхдийн их эмч Р.Оюунчимэгт 634.9 мянган төгрөг, нүүр амны их эмч С.Нарангэрэлд 634.9 мянган төгрөг нийт 1904.7 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

2015 оны 01 сарын 27-ны өдрийн А/14 дүгээр захирамжаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тул 1 сарын үндсэн цалингаар эрхлэгч эмч Б.Туяацэцэгт 742.1 мянган төгрөг, дотрын их эмч Н.Эрдэнэчимэгт 634.9 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, 2015 оны 10 сарын 26-ны А/193 дугаар захирамжаар Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Н.Эрдэнэчимэгт 3 улирлын ажлыг дүгнэж үндсэн цалингийн 30%-иар урамшуулж 190.7 мянган төгрөг, Хутаг-өндөр сумын Засаг даргын 2015 оны 12 сарын 15-ны А/221 дүгээр захирамжаар архивын улсын үзлэгт амжилттай дүн үзүүлсэн тул эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэчимэгт 1 сарын үндсэн цалин 742.1 мянган төгрөгөөр, 12 сарын 30-ны өдрийн А/235 дугаар захирамжаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тул 1 сарын үндсэн цалингаар эрхлэгч эмч Б.Туяацэцэгт 742.1 мянган төгрөг, дотрын их эмч Н.Эрдэнэчимэгт 742.1 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, 12 сарын 23-ны өдрийн А /234 дүгээр захирамжаар төсвийн ерөнхийлэн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээг В үнэлгээтэй дүгнүүлсэн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэчимэгт үндсэн цалингийн 80%-иар 507.9 мянган төгрөг нийт 4301.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

2016 онд төсөвт зардлыг 774122.8 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 533009.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажилчдын цалинд 352291.4 мянган төгрөг, урамшуулалт цалинд 20967.5 мянган төгрөг, гэрээт цалинд 1000.0 мянган төгрөг, ндш-д 40200.6 мянган төгрөг, тогтмол зардалд 43830.7 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 14749.5 мянган төгрөг, нормативт зардал буюу эм 26220.0 мянган төгрөг, хоол хүнс 9354.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 3794.1 мянган төгрөг, эд хогшил болон урсгал зардалд 826.8 мянган төгрөг, томилолт 530.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил 1408.4 мянган төгрөг, төлбөр хураамж бусад татварууд 1246.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3581.7 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 10045.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Сум дундын эмнэлгийн даргын 2016 оны 04 сарын 22-ны өдрийн Б/17 дугаар тушаалаар 30 ажилтанд 5-45%-иар 5024.7 мянган төгрөг, 2016 оны 07 сарын 20-ний өдрийн Б/28 дугаар тушаалаар 28 ажилтанд 30-45%-иар 4409.6 мянган төгрөг, 2016 оны 11 сарын 18-ны өдрийн Б/44 дугаар тушаалаар 28 ажилтанд 35-45%-иар 3899.3 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 23-ны өдрийн Б/59 дугаар тушаалаар 33 ажилтанд 15-45%-иар 6891.7 мянган төгрөг нийт 20225.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

Сум дундын эмнэлгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэчимэгт Хутаг-өндөр сумын Засаг даргын 2016 оны 04 сарын 27-ны өдрийн А/73 дугаар захирамжаар Б.Туяацэцэгт 1 сарын цалингаар 742.1 мянган төгрөг, Н.Эрдэнэчимэгт 742.1 мянган төгрөг, 2015 оны санхүүгийн тайланг хугацаанд нь зөрчилгүй тушаасан тул 2016 оны 05 сарын 17-ны өдрийн А/113 дугаар захирамжаар Н.Эрдэнэчимэгт 1 сарын цалин 742.1 мянган төгрөг, 2016 оны 08 сарын 17-ны өдрийн А/174 дүгээр захирамжаар дарга Б.Туяацэцэгт хагас жилийн ажлыг дүгнэж 1 сарын цалин 742.1 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 20-ны өдрийн А/229 дүгээр захирамжаар үр дүнгийн гэрээгээ А үнэлгээтэй

дүгнэгдэж 1 сарын цалин 742.1 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 23-ны өдрийн А/235 дугаар захирамжаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тул 1 сарын үндсэн цалингаар 742.1 мянган төгрөгийн нийт 4452.6 мянган төгрөгийн үр дүнгийн болон урамшуулалт цалин олгосон байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангаар:

2015 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1377659.5 мянган төгрөг дээр 400.0 мянган төгрөгийн хөргөгч, 150.0 мянган төгрөгийн үнэтэй 6 ш нийт 900.0 мянган төгрөгийн бичгийн ширээ, 50.0 мянган төгрөгийн үнэтэй 4ш нийт 200.0 мянган төгрөгийн урт модон сандал, 40.0 мянган төгрөгийн үнэтэй 2ш нийт 80.0 мянган төгрөгийн түшлэггүй модон сандал зэргийг худалдан авсан, 500.0 мянган төгрөгийн мэс заслын багажийг хандиваар, Байгаль хамгаалах сангаас багийн эмч нарт 1672.0 мянган төгрөгийн 4 ш нийт 6688.0 мянган төгрөгийн мотоцикль, улсын төсвөөс 455540.0 мянган төгрөгийн амбулаторийн барилгын санхүүжилт, 1145.0 мянган төгрөгийн явган хүний цементэн замыг бусад хөрөнгөнд тус бүр шилжүүлэн авч орлогодон нийт 1843112.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

2016 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1843112.5 мянган төгрөг дээр төсвийн хөрөнгөөр 899.0 мянган төгрөгийн нөөтбүүк, Хутаг тэмүүлэл ХХК-аас 1100.0 мянган төгрөгийн УВЧ шарлагын аппарат, 150.0 мянган төгрөгийн угаалгын индүү, 301.0 мянган төгрөгийн гал тогооны хэрэгсэл нийт 2450.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг 2016 оны 11 сарын 23-ны ИТХ- тэргүүлэгчдийн 43 тоот тогтоолоор бэлтгэж орлогодсон, ЭМЯ-аас 1309.5 мянган төгрөгийн 7 ш нийт 9166.6 мянган төгрөгийн өвчтөний ор, 2136.7 мянган төгрөгийн компьютер, 28555.0 мянган төгрөгийн рентген аппарат, 28633.0 мянган төгрөгийн хэвлэгч машин нийт 59324.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар, ДЗОУБ-аас 993.1 мянган төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч, 537.0 мянган төгрөгийн пульс тоологч 2 ш нийт 2067.1 мянган төгрөг, амбулаторийн барилгын санхүүжилт 22060.0 мянган төгрөгийг шилжүүлэн авч, сумын ИТХ-ын 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 19 тоот тогтоолоор 2ш компьютер бүхий 14 нэр төрлийн нийт 2588.3 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмж, 60 нэр төрлийн нийт 4348.3 мянган төгрөгийн эд хогшлийг тус тус акталж, нийт 1931244.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Бараа материалын 2015 оны эхний үлдэгдэл 24726.8 мянган төгрөг дээр эм боох материал 23901.4 мянган төгрөг, бичиг хэрэг 1908.1 мянган төгрөг, аж ахуйн материал 4963.9 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 23505.0 мянган төгрөг, хүнсний материал 11043.3 мянган төгрөг, бусад 835.3 мянган төгрөг нийт 66157.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 559.9 мянган төгрөгийн эм, 2500.0 мянган төгрөгийн аж ахуйн материал хандиваар, 20.0 мянган төгрөгийн хүнсний материал бусдаар авч, 67837.9 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 26125.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Бараа материалын 2016 оны эхний үлдэгдэл 26125.8 мянган төгрөг дээр эм боох материал 26220.1 мянган төгрөг, бичиг хэрэг 431.9 мянган төгрөг, аж ахуйн материал

9149.1 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 26901.2 мянган төгрөг, засварын материал 68.0 мянган төгрөг, хүнсний материал 9354.0 мянган төгрөг, баглаа боодол 110.0 мянган төгрөг нийт 72234.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 68705.2 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 4665.6 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж, оны эцэст 24989.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна

Өглөг, авлагын талаар: Эрүүл мэндийн төв нь 2015 оны эхэнд 1046.6 мянган төгрөгийн эмийн өглөгтэй байсныг барагдуулж, 1269.7 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны өглөгтэй, 550.2 мянган төгрөгийн хүмүүсээс авах авлагатай байсныг барагдуулж, бусад авлага 1269.7 мянган төгрөг, гэрэл цахилгааны 167.8 мянган төгрөгийн нийт 1437.5 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан.

2016 оны эхэнд 1269.7 мянган төгрөгийн хувь хүмүүст өгөх өглөгтэй байсныг барагдуулж 6.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй, 1437.5 мянган төгрөгийн авлагатай байсныг барагдуулж, 261.3 мянган төгрөгийн хаот-ын авлагатайгаар тайлан гарсан байна.

Нэмэлт санхүүжилт: Эрүүл мэндийн газраас 2015 онд нэмэлт санхүүжилтээр ирсэн 550.0 мянган төгрөгийг заавал хэвшүүлэх 21 дадлыг суртчилах зардалд зарцуулсан, 2016 онд улаан бурханы вакцинжуулалтын бензин шатахууны зардалд 315.2 мянган төгрөгийг зарцуулж тайланг дээд газарт явуулсан байна.

Шилэн дансны талаар: Эрүүл мэндийн төв нь шилэн дансны хуулийн дагуу 2016 онд мэдээллийг тавьсан ч батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны 13, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, тендерийн мэдээлэл 6, бусад мэдээлэл 8, нийт 27 мэдээллийг хоцроож, 40 мэдээлэл байршуулаагүй байна.

2015 оны 11 сарын 03-нд Хутаг-өндөр сумын ойн ангиас тарьцны үнэ 797855 төгрөг орж ирснийг тухайн өдөрт нь нярав Х.Мөнхцэцэгийн дансанд шилжүүлж Оройн буурал ХХК-аас 53 ш нарс авч эмнэлгийн хашаандаа тарьсан.

Шалгуулагчийн ололттой болон дэвшилттэй тал

1. Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж, зөрчилгүй тушаасан
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үзүүлэлтээр 2014, 2015, 2016 онуудад аймагт 1-р байр эзэлж хошой аварга болсон.
3. Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг зохих маягтын дагуу бүртгэж архивласан.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал

1. Хүнснээс бусад материалд агуулахын бүртгэл хөтөлдөггүй, хүнсний материалыг бүртгэхдээ материалыг өдрөөр биш хоолны өдөрлөгийн сарын дүнгээр хөтөлдөг.
2. Орлого зарлагын баримт болон шаардах хуудсыг оны эхнээс дугаарлаагүй, шаардах хуудсанд нягтлан бодогч гарын үсэг зурдаггүй.
3. Иргэдээс мах болон сүү тараг худалдан авахдаа шинжилгээний бичиг авсан ч санхүүгийн баримтанд архивладаггүй, нярав дээр хадгалдаг.
4. Цалин олгох болон цалингийн тооцооны хүснэгт, цалингийн картанд ажиллагсдаар гарын үсэг зуруулдаггүй, гарт олгох баримтыг санхүүгийн баримтанд хавсаргадаг.

5. Эм, хүнс болон түлээ, тээвэр шатахууны зардлаас бусад материалын тайланг зардлын нэр төрлөөр гаргаагүй нийлүүлж тайлан гаргадаг.
6. Иргэн Ч.Батцэцэгийн дансанд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 2015 оны 02 сарын 29-нд 948.5 мянган төгрөг, 04 сарын 08-нд 948.5 мянган төгрөг, 06 сарын 16-нд 696.5 мянган төгрөг нийт 2593.5 мянган төгрөг шилжүүлж ажлын хувцас хийлгэсэн ч хувь хүний орлогын албан татвар суутгаагүй.
7. 2015 онд нярав Б.Уянгын Хаан банкн дахь 5046299216 тоот дансанд
8. Сум дундын эмнэлгийн дарга Б.Туяацэцэг нь 2015 оны 01 сарын 05-наас жирэмсэний амралтаа авч ажлаа их эмч Н.Эрдэнэчимэгт хүлээлгэн өгсөн байхад даргын үүргийг түр орлон гүйцэтгэх шийдвэр нь 2015 оны 03 сарын 02-нд буюу 2 сарын дараа гарсан байна.
9. Сум дундын эмнэлгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэчимэг нь 2015 онд дотрын их эмчийн ажлыг хавсран ажиллахдаа даргын цалин 742153 төгрөгөөс 40%-иар тооцон 2015 оны 3 дугаар сараас 9 сар хүртэл 6 сарын хугацаанд $742153 \cdot 40 / 100 = 296861$ ₮, $634912 \cdot 40 / 100 = 253965$ ₮, $296861 \cdot 6 = 178116$ ₮, $253965 \cdot 6 = 1523790$ ₮, $178116 - 1523790 = 257376$ ₮/ төгрөг, дарга Б.Туяацэцэг нь 2016 онд эх барих эмэгтэйчүүдийн их эмчийн ажлыг хавсран ажиллахдаа даргын цалин 742153 төгрөгөөс 36%-иар тооцон 2016 оны 1 дүгээр сараас 12 сар хүртэл $742153 \cdot 36 = 267175$ ₮ /3124640-2941927=182713/ төгрөг нийт 440089 төгрөгийг илүү олгосон нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно./ заасан заалтыг зөрчсөн.
10. Сум дундын эмнэлгийн 2015 оны 12 дугаар сарын 21-ны Б/64 тоот тушаалаар 4 улирлын үр дүн болон ур чадварын нэмэгдлийг олгохдоо 16 албан хаагчдад 10-20%-иар ур чадварын нэмэгдлийг илүү тооцон 1381408 төгрөгийг илүү олгосон нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно./ 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./заасан заалтуудыг зөрчсөн.
11. Ээлжийн сувилагч болон асрагч нарын цалинг бодохдоо шөнийн цагийн нэмэгдлийг 2 дахинаар тооцон 2015 онд 10 хүнд 3536180 төгрөг, 2016 онд 15 хүнд 4116310 төгрөг нийт 7652490 төгрөгийн шөнийн нэмэгдэл цалинг илүү олгосон, шөнийн нэмэгдэл олгох талаар дотоод журам болон хамтын гэрээнд тодорхой заагаагүй байна.
12. Цалингийн нэмэгдлүүд нь санхүүгийн программ дээрх хүснэгтэнд багтахгүй бусад нэмэгдэл дээр нийлж бөөн дүнгээр гардаг эсвэл нэмэгдлүүд харагдахгүй олговол зохих дүн дээр нэмэгдэж харагддаг нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно./ 13.7-д Анхан

шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./заасан заалтуудыг зөрчсөн.

Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 2 заалттай 1 албан шаардлага, 1821.4 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоолоо. Шалгалтын хугацаанд 5 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Дүгнэлт

Тус ЭМТ-д Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь заалтууд, агуулахын бүртгэлийг өдөр тутам хөтөлдөггүй сарын тайлангийн дүнгээр хөтөлдөг, орлого зарлагын баримт болон шаардах хуудсыг оны эхнээс дугаарлаагүй, шөнийн цагийн нэмэгдлийг 2 дахинаар бодсон, хавсран ажилласаны нэмэгдлийг тухайн орон тооны цалингаар цалинжуулаагүй, ур чадварын нэмэгдлийн илүү олгосон зэрэг нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт хийгдээгүй гэж дүгнэлээ.

Цаашид анхаарах асуудал

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу албан ёсны баримтыг үндэслэн зарцуулж байх

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ О.ГАНТУЯА

